



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 5/13

Чингис хот

Цахимжуулалт хариуцсан ажилтнуудын
цалинг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4, 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 64 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр, 2017 оны “Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр тогтоол, Архивын Ерөнхий газрын 2020 оны А/03 дугаар тушаалын 6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн гэрээт ажилтнуудын сарын үндсэн цалинг 456172 /дөрвөн зуун тавин зургаа мянга нэг зуун далан хоёр/ төгрөгөөр, хоол, унааны зардлыг өдрийн 5000 /таван мянга/ төгрөгөөр тус тус тооцож 2020 оны 01 дүгээр сарын 02-ний өдрөөс олгосугай.

2. Хөдөлмөрийн гэрээ, нормын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Архивын тасгийн дарга /Б.Мөнгөнцэцэг/-д үүрэг болгосугай.

3. Уг зардлыг Аймгийн Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансны гэрээт ажилчдын цалингийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /Г.Ариунхүүд/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.ГАНБААТАР